



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/215

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам”, 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”, нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн өмчит Ерөнхий боловсролын сургуулиудын 2021-2022 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангуулах ажлын хүрээнд нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад болон түрээсээр эзэмшүүлсэн байр талбайд хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хяналт шалгалттай холбоотой зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Шалгалттай холбоотой гарах зардлыг батлагдсан төсвийн дагуу олгохыг ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид заасан журам, батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж гүйцэтгэн, санал дүгнэлт гаргаж 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг /М.Мандах/-т даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /Э.Болор-Эрдэнэ/-д даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000747

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 20 -ны өдрийн А/2021 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:
М.Мандах

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн холбогдох мэргэжилтэн

Нийслэлийн Боловсролын газрын холбогдох мэргэжилтэн

Дүүргийн Боловсролын хэлтсийн холбогдох мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:
Ц.Цолмон

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн